

АГУУЛГА



01 Төлөөлөгчийн үйл ажиллагаа



04 Хурлын хөгжлийн хороод



02 Хурлын хуралдаан



05 Хяналт шалгалтын ажил



03 Хурлын зөвлөл



06 Хурлын дэргэдэх зөвлөл



ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

Монгол улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар бүлэгт заасан 18 заалт

01

Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн тэсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах

02

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

03

нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

04

орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

05

тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

06

Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих;

07

хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх;

08

хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

09

энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах.....;



2024 оны 10 дугаар сарын 11-нд орон даяар явагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн сонгуулиар сонгогдсон бүрэлдэхүүн 10 дугаар сарын 23-нд анхны хуралдаанаа хийж төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоолыг баталснаар өнөөдөр 9 дэх бүрэн эрхийн буюу 2024-2028 оны Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 21 төлөөлөгчтэй бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна.

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын сонгуулийн 9 дэх бүрэн эрх

2024.10.23

2025.12.18

№	Хуралдсан байдал	Хэлэлцсэн асуудал	Батлагдсан тогтоолын тоо	Дундаж ирц
2024 он				
Анхдугаар хуралдаан	1	5	5	95%
Ээлжит хуралдаан	2	26	26	95%
Нийт	3	31	31	95%
2025 он				
Ээлжит хуралдаан	4	30	30	80,5%
Ээлжит бус хуралдаан	3	6	6	70%
Нийт	7	36	36	75%


Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хугацаанд ээлжит 7, ээлжит бус 3 нийт 10 удаагийн хуралдаан хийж холбогдох тогтоол шийдвэрүүдийг гарган үүрэг даалгаврыг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.



Хуралдаанаас гарсан онцлох шийдвэрүүдээс

АНХДУГААР ХУРАЛДААН

- Төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай
- Сумын ИТХ-ын даргыг сонгох тухай
- Сумын Засаг даргад нэр дэвшүүлэх тухай




ЭЭЛЖИТ БУС 1 ДҮГЭЭР ХУРАЛДААН

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай.



ЭЭЛЖИТ 1 ДУГААР ХУРАЛДААН

- Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам батлах тухай.



ЭЭЛЖИТ 2 ДУГААР ХУРАЛДААН

- Сумын 2025 оны Төсөвт тодотгол хийх тухай.






Хуралдаанаас гарсан онцлох шийдвэрүүдээс

ЭЭЛЖИТ БУС 2 ДУГААР ХУРАЛДААН

- Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай
- Сумын хамтарсан багийг шинэчлэн байгуулах тухай



ЭЭЛЖИТ 3 ДУГААР ХУРАЛДААН

- Жаргалант суманд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтүүд
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны 2025 оны биелэлт



ЭЭЛЖИТ 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН

- 2026 онд Жаргалант суманд хэрэгжих хөтөлбөрүүдийн төлөвлөгөө батлах тухай
- Сумын 2026 оны төсөв батлах тухай



Хуралдаанаас гарсан шийдвэрүүдээс



Энэхүү 9 дэх бүрэн эрхийн ИТХ 2024 оны 10 дугаар сарын 23-ны анхны хуралдаанаас хойш Хурал өнөөдрийн байдлаар ээлжит 7, ээлжит бус 3, нийт 10 удаагийн хуралдаанаар сум, орон нутгийн нийгэм, эдийн засаг, цаг үетэй холбоотой 67 асуудлыг авч хэлэлцэн холбогдох тогтоол шийдвэр гаргаад байна.

Энэ удаагийн бүрэн эрхийн Хурал хурлын анхдугаар хуралдаан, ээлжит болон ээлжит бус хуралдаан, өргөтгөсөн хуралдааны дэгүүд болон Хурлын хорооны үйл ажиллагааны журмыг тус тус шинэчлэн баталлаа. Мөн хороодын бүтэц, бүрэлдэхүүн, тоог өөрчлөн хороог 4 болгон багасгаж, хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй, 1 төлөөлөгч нэг л хороонд ажиллахаар хуваарилалт хийн, хороодын хариуцах чиглэлүүдийг чиг үүргийн давхардал үүсгэхгүйгээр тодорхой болгон баталлаа.

Ил тод байдал



Хурлын зөвлөлийн хуралдаан

4



Хурлын хуралдаан

10



Хурлын хороодын ажиллагаа хөгжлийн үйл

3



Хурлын зөвлөлийн ажиллагаа дэргэдэх үйл

3



Цаг үеийн мэдээ

31




Видео мэдээ

10



Ажлын хэсэг

2



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай мэдээлэх, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор хурлаас батлагдан гарсан тогтоол шийдвэрүүдийн мэдээллүүдийг өөрийн албан ёсны цахим хуудас болох <http://jargalant.orkhon.khural.mn/> болон Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ, Улсын тэргүүний Жаргалант сум цахим хуудсанд цаг тухай бүрт байршуулж байна.


Хурлын зөвлөл

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51.1 дэх хэсэгт иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна, Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ гэж заасан. Хуулийн дагуу Жаргалант сумын ИТХ-ын Зөвлөл таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.



Нийт хуралдсан тоо

4



Дундаж ирц

83%



Нийт хэлэлцсэн асуудлын тоо

40

Хурлын Зөвлөлийн дарга Ш.Билгүүнбаатар, гишүүд Ж.Дэлхийцэцэг, О.Энхтуяа, Э.Пүрэвсүрэн, Б.Мөнх-Эрдэнэ

Хурлын хөгжлийн хороод

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана хэмээх хуулийн заалтын дагуу өөрийн нутаг дэвсгэр, хүн амын тоо, газар зүйн байршил, аж ахуй нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, төлөөлөгчдийн тоог харгалзан тус бүр 5 гишүүнтэйгээр доорх 4 хөгжлийн хороодыг байгуулан ажиллуулж байна. Үүнд:

Эрх зүй, нутгийн удирдлага, нийгмийн хөгжлийн хороо Дарга: Ж.Алтантөгс Гишүүд: Т.Лхагвацэрэн, Д.Нямдаваа, Э.Сумъяахорол, Б.Мөнх-Эрдэнэ	Эдийн засаг, төсөв, санхүүгийн хөгжлийн хороо Дарга: Н.Хадаа Гишүүд: О.Цэрэндулам, Э.Пүрэвсүрэн, Д.Төмөрчөдөр, Б.Пүрэвсүрэн
Дэд бүтэц, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо Дарга: Г.Хангал Гишүүд: Р.Эрдэнэ-очир, Б.Баттулга, О.Энхтуяа, Ч.Батсуурь	Ёс зүй, өргөдөл гомдлын хороо Дарга: Ж.Эрдэнэ-Очир Гишүүд: Ж.Дэлхийцэцэг, П.Барсболд, Л.Учрал, Ч.Сувдаа

Хороод өөрсдийн жилийн ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн батлаад хэрэгжүүлж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд хяналт тавих хороодын хуваарийг ИТХ-ын даргаар батлуулан мөрдөж байна. Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дэд бүтэц, байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн хөгжлийн хороо “Малжуулах”, “Ногоон Жаргалант”, “Жаргалантын ногоочид” хөтөлбөрүүдтэй, Эдийн засаг, нутгийн удирдлага, нийгмийн хөгжлийн хороо “Эрүүл Жаргалантчууд”, “Соёлыг дэмжих” хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй танилцан санал, дүгнэлт гаргасан. Эдийн засаг, нутгийн удирдлага, нийгмийн хөгжлийн хороо мөн багуудад хийгдэж буй зам засвар, Жаргалант болон Улаантолгой багийн халуун ус, Хог хаягдалын цэг, Улаантолгой багийн Цэцэрлэгт хүрээлэн, үерийн зурвас, уст цэгүүдийн ажлуудын гүйцэтгэлд хяналт тавин, гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажиллагсадтай санал солилцлоо.

2025 онд Хурлын шийдвэрийн биелэлт, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил, орон нутгийн өмчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр Хурлын даргын захирамжаар Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил үйлчилгээ, түүний хэрэгжилт, хадгалалт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, тэдгээртэй холбогдуулан гарсан журмуудын хэрэгжилтэд хяналт тавих, тооллого явуулах, дүгнэлт гаргах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хэсгийг Ж.Эрдэнэ-Очир төлөөлөгчөөр ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан ба ажлын хэсгийн тайлангийн сонсголын хуралдаанаар хөтөлбөрүүдийн биелэлт, өмчийн ашиглалт, захиран зарцуулалт, сумын байрнуудын орцны засвар, “Жаргалант-Ус ДТС” ОНӨХК-ийн засварын талаар дутуу мэдээллүүдийг бүрэн гүйцээж сумын ИТХ -ын хуралдаанд оруулахыг даалгалаа. Мөн Хурлын даргын захирамжаар Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-ын төсөлтэй танилцах, дүгнэлт гаргах ИТХ-ын ажлын хэсгийг Н.Хадаа төлөөлөгчөөр ахлуулан байгуулж журмын төсөлтэй танилцан, дүгнэлт гаргаж ажлын хэсэгтэй зөвшилцсөнөөр ажлын хэсэг журмыг эцэслэн боловсруулж сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна.

Хяналт шалгалтын ажил



Хурал захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх бүрэн эрхийн хүрээнд “Сумын 500 тонны төмс, хүнсний ногооны зоорь ажиллуулах журам”, “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-ыг тус тус баталлаа. Мөн үнийн өсөлт, цаг үеийн нөхцөл байдлын шаардлагаар “Агро үйлчилгээний техникийн үнэ тарифыг шинэчлэн тогтоох тухай” болон “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолуудыг батлаад байна.



Хурал бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын явц, гүйцэтгэлтэй танилцах, багийн иргэдэд хөрөнгө оруулалтын ажлуудын талаар мэдээлэл өгөх, иргэд, сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан хүсэлт, санал, гомдлыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид өөрсдийн сонгогдсон тойрог, багуудад 2025 оны 9 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд ажиллаа. Хурлын төлөөлөгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, иргэдэд мэдээлэл өгөхөөр сумын удирдлагууд, холбогдох алба, мэргэжилтнүүд ажилласан ба хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлтэй танилцах үеэр гүйцэтгэгч ААН, компаниудын төлөөллүүд мөн байлцлаа.



Иргэд сонгогчдод мэдээлэл хүргэх, хурлын байгууллагын үйл ажиллагааг таниулан сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор Жаргалант сумаас аймгийн ИТХ болон сумын ИТХ-д сонгогдсон төлөөлөгчид, аймгийн төрийн байгууллагууд оролцсон “Иргэдийн оролцоо, төлөөлөгчийн манлайлал, төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөгийг аймгийн ИТХ-тай хамтран сумандаа 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр амжилттай зохион байгууллаа.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, бусад хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэн, орон нутагт нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, УИХ, Засгийн газар, аймгийн ИТХ-ын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагын ажлыг удирдан чиглүүлэх, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дээшлүүлэн хөгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэд, сонгогчдын нийтлэг эрх ашигт нийцүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна.





ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг судлан тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2025 оны 02 дугаар сарын 12

ЖАРГАЛАНТ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: Жаргалант сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцөл, хүчин зүйлсийг тогтоон арилгах зэрэг чиглэлээр зохих хууль хяналтын болон бусад байгууллагуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхойлж, хамтын ажиллагааг уялдуулж гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад оршино.

Д/Д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн түвшин	төсөв
НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДЛЫН ХҮРЭЭНД						
1.1	Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, зөвлөлөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.	Жилдээ	Сумын ГХУСАЗС3-ийн дарга	Сумын ГХУСАЗС3-ийн гишүүд	Сумын ГХУСАЗС3-ийн хуралдааныг тогтмол явуулж, үйл ажиллагааг хагас бүтэн жилээр дүгнэсэн байна.	-

1




ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН **11**



ХУРАЛДСАН
ТОО **3**



ХЭЛЭЛЦСЭН
АСУУДАЛ **10**



ЗӨВЛӨМЖ **1**



ИРСЭН БИЧИГ **15**



ЯВУУЛСАН
БИЧИГ **12**

4 Зорилтын хүрээнд | **36** Арга хэмжээ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ:

- Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг 10 аж ахуйн нэгж, иргэнд 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах сургалт явуулан, хяналт шалгалтыг тогтмол хийж зөвлөмж, зөвлөгөөг өгч, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэн болон 21 насанд хүрээгүй иргэнд архи согтууруулах ундаа худалдаалахгүй байх, тогтоосон цагийн хуваарийн дагуу үйл ажиллагааг явуулах талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна.
- Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөт ажлын дагуу сумын хэмжээнд гал түймрийн эрсдэл их гарч байгаатай холбогдуулан салбар зөвлөлийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дугаар удирдамжийн дагуу аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 56 дугаар ангийн 2,3,4 дүгээр салааны 36 албан хаагчийн бүхэлдэхүүн болон сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагчид хамтран 5 чиглэлд ажилласан. Албан байгууллага, айл өрхүүдийн өвс тэжээлийн хадгалалт, галлагаа болон зуух яндан, хийн баллоны ашиглалт, цахилгааны монтажийн аюулгүй байдал зэрэг асуудлаар хяналт шалгалтыг хийж, зөвлөмж өгч ажилласан.
- Сумын ГХУСАЗСЗ-ийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн №14 дүгээр удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр ГХУСАЗСЗ-ийн гишүүд сумын дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж заавар, зөвлөмжийг өгч ажилласан.



ИТХ-ын Ажлын алба нь ИТХ-ын хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдуулах, гаргасан шийдвэрийг албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэх, иргэд, ААН байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах, бүртгэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах, хариуг хүргүүлэх ажлыг хариуцан, сумын ИТХ-ын болон Хурлын төлөөлөгчийн бие даасан байдлыг хангаж ажиллах, хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтэд Хурлын зөвлөл, хороо, төлөөлөгчид хяналт тавих ажлыг дэмжин туслан гүйцэтгэдэг байгууллага билээ. Энэхүү 9 дэх бүрэн эрхийн Хурлын ээлжит бус I хуралдаанаар Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлаад Хурлын даргаас гадна төрийн захиргааны удирдах 1, гүйцэтгэх 1, төрийн үйлчилгээний 2 албан хаагчтай, хурлын албаны санхүүгийн үүргийг ЗДТГ-ын нягтлан нь хавсран гүйцэтгэж 0,5-аар цалинжин үйл ажиллагаа явуулж байна.



- Цаашид иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төлөөлөгчдийн бие даасан байдлыг бэхжүүлэх, Хурлын хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хороодын жилийн төлөвлөсөн ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүднээс Хурлын төсөвт тодорхой хөрөнгө суулган дэмжихээр төлөвлөж байна.
- ИТХ-ын төлөөлөгчдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, бодлого төлөвлөлтөд идэвхитэй оролцох тал дээр хамтран ажиллах
- ИТХ-ын үйл ажиллагааг бүрэн цахимд шилжүүлэх
- ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтанд хамруулах
- ИТХ-ын ажлын албыг чадавхжуулах
- ИТХ-ын хуралдаан болон бусад үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох
- ИТХ-ын хурлын ирц, оролцоотой холбоотой мэдээллийг иргэдэд нээлттэй танилцуулж байх
- ЗДТГ, бусад төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний санал, төлөвлөгөө
- Төрийн албан хаагчдыг чадавхжуулах
- ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг ханган ажиллах
- Албан хэрэг хөтлөлт, тайлагнал дээр жишиг тайлангийн хүснэгтээр тайлагнах
- ИТХ-ын төлөөлөгчдөд цаг үеийн мэдээллийн шуурхай хүргэж ажиллах
- Хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үйл ажиллагаанд ИТХ-ын төлөөлөгчдийг урилгаар оролцуулах
- Ажлын хэсгүүд хамтран ажиллах

***АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА.***